



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хувийн хэвшлийн хуулийн этгээдээс өөрийн хүсэлтээр төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн, нийт 637,684,900.00 (зургаан зуун гучин долоон сая зургаан зуун наян дөрвөн мянга есөн зуу) төгрөгийн балансын үнэ, 217,603,625.66 (хоёр зуун арван долоон сая зургаан зуун гурван мянга зургаан зуун хорин таван төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий нэгдүгээр хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 4,611,457,365.48 (дөрвөн тэрбум зургаан зуун арван нэгэн сая дөрвөн зуун тавин долоон мянга гурван зуун жаран таван төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгө (өр төлбөр)-ийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгө, өр төлбөрт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем”-д бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ


132610694
10-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн
.....*218*..... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Таслах хаалт Ф300/Ф250мм	2017	ш	6	52,974,006.16	28,547,103.32	24,426,902.84
2	Ган яндан хоолой ФФ300/250мм	2017	хос.метр	490.7	584,710,893.84	189,056,522.34	395,654,371.50
Нийт дүн				496.7	637,684,900.00	217,603,625.66	420,081,274.34
					(зургаан зуун гучин долоон сая зургаан зуун наян дөрвөн мянга есөн зуу)	(хоёр зуун арван долоон сая зургаан зуун гурван мянга зургаан зуун хорин таван төгрөг жаран зургаа мөнгө)	(дөрвөн зуун хорин сая наян нэгэн мянга хоёр зуун далан дөрвөн төгрөг гучин дөрвөн мөнгө)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн
..... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадлын нэгж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хөрөнгөд бүртгэх дүн
1	Алсын удирдлага, хяналтын системтэй цахилгаан активатор бүхий бөмбөлөгөн хаалт	2024	Ган бөмбөлөгөн хаалт DN500-DN800	ш	18	4,611,457,365.48
2		2024	Даралт температур мэдрэгч	ш	114	
3		2024	Удирдлагын самбар	ш	13	
Нийт дүн					145	4,611,457,365.48
						(дөрвөн тэрбум зургаан зуун арван нэгэн сая дөрвөн зуун тавин долоон мянга гурван зуун жаран таван төгрөг дөчин найман мөнгө)